

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.. оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ /АНХДАГЧ ТӨСӨЛ/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь үндэсний баялгийн сангийн төрлийг тогтоож, тус сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд баримтлах нийтлэг зарчим, сангийн тайлагнал, ил тод байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Үндэсний баялгийн сангийн хууль тогтоомж

2.1.Үндэсний баялгийн сангийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь үндэсний баялгийн сан (цаашид “баялгийн сан” гэх)-ийн төрлийг тогтоож, сангийн хөрөнгийг удирдахад баримтлах нийтлэг зарчмыг тогтоох, тайлагнах, ил тод байдлыг хангахтай холбогдсон харилцаанд үйлчилнэ.

3.2.Баялгийн сангийн төрөл, түүний эх үүсвэр, зарцуулалт, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон нарийвчилсан харилцааг Ирээдүйн өв сангийн тухай хууль, Хөгжлийн сангийн тухай хуулиар тус тус зохицуулна.

4 дүгээр зүйл.Нийтлэг зарчим

4.1.Баялгийн сангийн үйл ажиллагаанд дараах нийтлэг зарчмыг баримтална:

- 4.1.1. хараат бус, бие даасан байх;
- 4.1.2. ил тод байх;
- 4.1.3. зохистой удирдах;
- 4.1.4. үр ашигтай байх;
- 4.1.5. хариуцлагатай байх.

5 дугаар зүйл. Баялгийн сангийн төрөл

5.1. Үндэсний баялгийн сан нь одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг тэгш, шударга хүртээхэд чиглэгдсэн үйл ажиллагааг дагнан эрхлэх дараах төрөлтэй байна:

- 5.1.1. Ирээдүйн өв сан;
- 5.1.2. Хөгжлийн сан.

5.2. Энэ хуулийн 5.1-д заасан санг шинээр байгуулахад хуульд заасан журмын дагуу байгуулж, татан буулгана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БАЯЛГИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

6 дугаар зүйл. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлага, түүнд тавигдах шаардлага

6.1. Энэ хуулийн 5.1-д заасан баялгийн сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдана.

6.2. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагад дараах нийтлэг шаардлага тавигдана:

- 6.2.1. хуульд зааснаас бусад тохиолдолд зээл авахгүй байх;
- 6.2.2. хуульд зааснаас бусад тохиолдолд сангийн хөрөнгийг барьцаалах, зээл олгох, зээлийн баталгаа, батлан даалт гаргах болон бусад аливаа хэлбэрээр бусдын үүргийн гүйцэтгэлийг хангах гэрээ, хэлцэл байгуулахгүй байх;
- 6.2.3. санхүүгийн хөшүүрэг оролцсон аливаа төрлийн гэрээ, хэлцэл хийхгүй байх;
- 6.2.4. үүсмэл санхүүгийн хэрэгслийг зөвхөн хөрөнгө оруулалтын

эрсдэлийг хаах, бууруулах зорилгоор ашиглах.

6.3.Баялгийн сангийн хөрөнгөөр цэрэг, зэвсэг, хар тамхи, мансууруулах бодис, тамхи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, хуулиар хориглосон бусад үйл ажиллагаанд хөрөнгө оруулахыг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД

7 дугаар зүйл.Баялгийн сангийн тайлагнал, ил тод байдал

7.1.Баялгийн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг холбогдох хуульд заасны дагуу гаргана.

7.2.Баялгийн сан, түүний үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуульд заасны дагуу олон нийтэд мэдээлнэ.

8 дугаар зүйл.Хариуцлага

8.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

9.1.Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ